

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ /2014 ОН

Төрийн байгууллагын соёл болон төрийн албан хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх нь тус зөвлөлийн үндсэн чиг үүрэгт хамааралтай үүрэг, зорилтын нэг билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2.6, 2.7-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо нь төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороодоос төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг 2014 оны бүтэн жилийн байдлаар авч нэгтгэн ажиллалаа.

Төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороонуудаас ирүүлсэн мэдээг нэгтгэн үзвэл 2014 онд нийт 347 ёс зүйн зөрчил бүртгэгдсэнээс төрийн захиргааны удирдах албан тушаалтантай холбоотой 31, төрийн захиргааны гүйцэтгэх албан хаагчтай холбоотой 316 ёс зүйн зөрчил байна. Өмнөх оныхтой харьцуулахад бараг гурав дахин олон ёс зүйн зөрчил бүртгэгджээ. Үүнээс удирдах ажилтны ёс зүйтэй холбоотой гомдол 2.6 дахин, гүйцэтгэх албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол 3 дахин илүү байна.

*Ёс зүйн зөрчлийг хүлээн авсан үндэслэл, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн зэрэг дэлгэрэнгүй байдлаар дараах хүснэгтээр нэгтгэн гаргав. Үүнд:*

| 2014 он                   | Ёс зүйн зөрчлийн тухай мэдээлэл хүлээн авсан үндэслэл |            |  |                                   |                                    | Ёс зүйн зөрчлийг анх буюу давтан үйлдсэн аль нь болох |        | ТАХ-ийн ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн байдал |              |   |               |                           |   |
|---------------------------|---|------------|--|-----------------------------------|------------------------------------|---|--------|---|--------------|---|---------------|---------------------------|---|
|                           | Журмын 1.2  |            | Журмын 2.2.5                                   |                                   |                                    |   |        | Ёс зүйн хорооны дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн эсэх                       |              | Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэр |               | Сахилгын шийтгэлийн төрөл |   |
|                           | Гомдлоор  | Мэдээллээр | Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мөрөөр | Ёс зүйн хороо өөрийн санаачлагаар | Байгууллагын удирдлагын шийдвэрээр | Анх   | Давтан | Зөвшөөрсөн  | Зөвшөөрөөгүй | ТАХ-ын 26.1.1                             | ТАХ-ын 26.1.2 | ТАХ-ын 26.1.3             | Сахилгын шийтгэл ногдуулах шаардлагагүй гэж үзсэн |
| Удирдах албан тушаалтан   | 11  | 4          | -  | 1                                 | 15                                 | 28  | 3      | 26  | 5            | 8   | 12            | 1                         | 10  |
| <b>31 ёс зүйн зөрчил</b>  |   |            |  |                                   |                                    |   |        |   |              |   |               |                           |   |
| Гүйцэтгэх албан тушаалтан | 51  | 47         | 14   | 7                                 | 197                                | 260   | 56     | 289   | 27           | 93  | 148           | 33                        | 42  |
| <b>316 ёс зүйн зөрчил</b> |   |            |  |                                   |                                    |   |        |   |              |   |               |                           |   |
| Нийт ёс зүйн зөрчил       | 62  | 51         | 14   | 8                                 | 212                                | 288   | 59     | 315   | 32           | 101                                       | 160           | 34                        | 52  |
| <b>347 ёс зүйн зөрчил</b> |   |            |  |                                   |                                    |   |        |   |              |   |               |                           |   |

Дээрх хүснэгтээс харахад төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн талаарх иргэдийн гомдол, мэдээллийг үндэслэн ёс зүйн хороо авч хэлэлцсэн тохиолдол 113 байхад байгууллагын удирдлагын санаачлага, шийдвэрээр ёс зүйн зөрчлийг авч хэлэлцсэн тохиолдол бараг 2 дахин их буюу 212 байна. Харин ёс зүйн хороод хэвлэл мэдээллийн хэрэгслийн баримтат мэдээлэл болон өөрийн санаачлагаар төрийн албан хаагчийн ёс зүйн үйлдлийг ёс зүйн хороо авч хэлэлцсэн тохиолдол харьцангуй цөөн байна. Энэ нь ёс зүйн хороод өөрийн санаачлагатай, идэвхитэй ажиллах байдал сулавтар байгааг харуулж байна.

Ёс зүйн зөрчлийг анх удаа гаргасан 288 албан хаагч байгаа бол давтан гаргасан 59 албан хаагч байгаагаас Ёс зүйн хорооны дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн 315, хүлээн зөвшөөрөөгүй 32 албан хаагч байна.

Ёс зүйн хороод төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой иргэдийн ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тухайн асуудлыг авч хэлэлцээд тэдгээр зөрчилд сахилгын шийтгэл оногдуулах эсэх шийдвэрийг гаргадаг. 2014 онд дээрх 347 ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг авч хэлэлцээд 15 хувьд нь буюу 52 тохиолдолд нь сахилгын шийтгэл ногдуулах шаардлагагүй гэсэн шийдвэрийг гаргасан бол нийт зөрчлийн 85 хувь буюу 295 зөрчилд нь Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулах шийдвэр гаргажээ.

Ёс зүйн хороодын дээрх шийдвэрээр төрийн албан хаагчдад ногдуулсан сахилгын шийтгэлийг төрлөөр авч үзвэл:

- 101 албан хаагчид -сануулах /ТАТХ-ийн 26.1.1/,
- 160 албан хаагчид -албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах /ТАТХ-ийн 26.1.2/,
- 34 албан хаагчид -төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах /ТАТХ-ийн 26.1.3/ гэсэн сахилгын шийтгэлийг тус тус ногдуулжээ.

Эндээс харахад материаллаг /цалин бууруулах/ болон ёс зүйн /сануулах/ шийтгэл зонхилж байгаа нь харагдана. Төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл нийт сахилгын шийтгэлийн 11.5 хувийг эзэлж байгаа бөгөөд ийм шийтгэл авсан албан хаагч 33 байхад удирдах албан тушаалтан 1 байлаа.

Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн тухай сүүлийн 4 жилийн байдлыг харьцуулан үзэхэд өнгөрөгч 2014 онд бүртгэгдэж ёс зүйн хороодоор хэлэлцэгдсэн зөрчлийн тоо өмнөх 2 жилийн буюу 2013, 2012 оны нийлбэр дүнгээс ч илүү байгаа нь харагдана.

Ийнхүү ёс зүйн зөрчил гэнэт өссөн харагдаж байгаа нь хоёр талтай юм. Нэг талаас ёс зүйн зөрчлийн илрүүлэлт дээшилсэн, нөгөө талаас мэдээж ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид цөөнгүй байгаагийн илрэл гэж үзвэл зохино.

Төрийн албаны зөвлөлөөс ёс зүйн хороодын гишүүдэд арга зүйн зөвлөгөө өгч, ажлыг нь дүгнэж ажилласан, төрийн албан хаагчдын дунд ёс зүйн сургалтыг жил бүр зохиож байгаагийн дүнд хороодын үйл ажиллагаа тогтмолжиж, идэвхжсэн нь албан хаагчдын ёс зүйгүй үйлдлээр хайхрамжгүй, тоомжиргүй хандах байдал өөрчлөгдөж, тийм тохиолдол болон түүнтэй холбоотой иргэдийн гомдол, мэдээлэлд нааштай хандаж, зохих журмын дагуу авч хэлэлцэх, хариуцлага тооцох байдалд нааштай хандлага гарч буй нь ажиглагдлаа.

*Ёс зүйн зөрчлийг сүүлийн 4 жилийн байдлаар харьцуулан үзвэл:*

